

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/2.2 дугаар зүйлийн 10, 11, 12 дахь хэсэг:**

“10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв сэжигтэн өөр шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт оршин байгаа нь тогтоогдвол тухайн газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, эсхүл тухайн баривчлах ажиллагаа явагдсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

12.Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг тухайн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.”

**2/3.1 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

“5.Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3 дахь хэсэгт заасан таслан сэргийлэх арга хэмжээ, 31.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх журмыг Улсын Дээд шүүх батална.”

**3/5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**4/14.10 дугаар зүйлийн 6, 7, 8, 9 дэх хэсэг, тайлбар:**

“6.Мөрдөгч яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 5 хоногийн өмнө прокурорт хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.

8.Шүүх цагдан хорих хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.

9.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчийн цагдан хорих хугацааг баривчилсан, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолно.

Тайлбар: - Шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд хамаарахгүй.”

#### **5/17.2 дугаар зүйлийн 5-12 дахь хэсэг:**

“5.Гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзсан яллагдагчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Өмгөөлөгчдийн холбооны холбооны ерөнхийлөгч хамтран баталж, хэрэгжүүлнэ.

6.Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн яллагдагчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх, шаардлагатай бол орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах;

6.2.өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах;

6.3.ямар хэрэгт яллагдаж байгаага мэдэх, тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар мэдээлэл авах;

6.4.прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

6.5.эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.6.прокурорын яллах дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримттай танилцах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлт гаргах, шинээр баримт сэлт гаргаж өгөх;

6.7.шүүх хуралдаанд биечлэн оролцож, прокурортой хийсэн тохиролцооны талаар тайлбар хэлэх;

6.8.мөрдөгч, прокурор, шүүгч, нарийн бичгийн даргыг татгалзах гаргах хүсэлт гаргах;

6.9.шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө прокурортой хийсэн тохиролцооноос татгалзах;

6.10.шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай хүсэлт гаргах;

6.11.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр давж заалдах журмаар гомдол гаргах;

6.12.бусад оролцогчоос гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар гаргах.

7.Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн хохирогчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

7.1.эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх, шаардлагатай бол орчуулагч, хэлмэрч авах;

7.2.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;

7.3.өөрт учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

7.4.хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан саналыг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

7.5.шүүхэд баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;

7.6.өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах;

7.7.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл авах;

7.8.мөрдөгч, прокурор, шүүгч, нарийн бичгийн даргыг татгалзах гаргах хүсэлт гаргах;

7.9.шүүх хуралдаанд биечлэн оролцож, прокурорын яллагдагчтай хийсэн тохиролцооны талаар санал хэлэх;

7.10.шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, засвар оруулах талаар хүсэлт гаргах;

7.11.шүүх прокурорын яллагдагчтай хийсэн тохиролцоог баталж шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр давж заалдах гомдол гаргах;

7.12.бусад оролцогчийн гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар гаргах.

8.Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч зарим хэргээ хүлээн зөвшөөрөөгүй бол түүнд холбогдох хэргийг бүхэлд нь хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.

9.Нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг хамтран үйлдсэн яллагдагч нарын зарим нь гэм буруугаа бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн яллагдагч нарт холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.

10.Гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд холбогдох хэргийг бусад яллагдагч нарт холбогдох хэргээс тусгаарласан бол түүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж болно.

11.Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд заасныг журамлан ял оногдуулахад саад болохгүй.

12.Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.”

### **6/17.3 дугаар зүйлийн 5-9 дэх хэсэг:**

“5.Яллагдагчийн хүлээн зөвшөөрсөн прокурорын саналд энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах нөхцөл байдлыг тусгаж, хэрэгт хавсаргана.

5.1.эрүүгийн хариуцлагын талаар тохиролцоо хийгдсэн огноо, газар;

5.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан албан тушаалтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

5.3.яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн талаарх мэдээлэл;

5.4.гэмт хэрэг үйлдсэн огноо, газар, хэргийн товч агуулга;

5.5.гэмт хэргийн үндсэн шинж;

5.6.гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, хор уршгийн шинж чанар;

5.7.яллагдагчийн хохирол нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн байдал;

5.8.яллагдагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал;

5.9.яллагдагчийн биеийн байцаалт;

5.10.яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол түүний үйлдэл тус бүрт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ;

5.11.Эрүүгийн хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмын ял нэгтгэснээр яллагдагчийн нийт эдлэх ялын төрөл, хэмжээ;

5.12.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хураалгах хөрөнгө, орлого;

6.Прокурор яллагдагчийн гэм буруу, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар яллагдагчийн хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан саналыг яллах дүгнэлтийн хавсралтад тусгаж, хэргийг 7 хоногийн дотор шүүхэд шилжүүлнэ.

7.Прокурорын яллах дүгнэлтийн хавсралтад дараахь зүйлийг тусгана.

7.1.яллагдагчтай хийсэн тохиролцооны агуулга;

7.2.яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ;

7.3.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яллагдагч нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байдал;

7.4.мөрдөн шалгах ажиллагаанд гарсан зардлын тооцоо;

7.5.хэрэгт хураагдсан, битүүмжлэгдсэн хөрөнгө, эд мөрийн баримт, тэдгээрийн оршин байгаа газар;

7.6.прокурорын яллагдагчтай хийсэн тохиролцоог батлах хүсэлт.

8.Прокурор хэргийг хэзээ, аль шүүхэд шилжүүлсэн талаар яллагдагч, түүний өмгөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ.

9.Прокуророос эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой санал, хүсэлтээ харьяалах шүүхэд гаргана.”

#### **7/17.4 дүгээр зүйлийн 10, 11 дэх хэсэг:**

“10.Прокурор гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн яллагдагч, түүний өмгөөлөгчтэй эрүүгийн хариуцлагын талаар тохиролцоо хийхэд баримтлах аргачлал, журмыг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газартай хамтран баталж, хэрэгжүүлнэ.”

11.Гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрч, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хүсэлт гаргасан яллагдагч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал төлөхөөс чөлөөлөгдөнө.”

#### **8/34.16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй тухай прокурорын саналыг үндэслэн шүүх хуралдааныг нэг удаа 30 хүртэл хоногоор хойшлуулж болно.”

#### **9/39.9 дүгээр зүйлийн 1.6, 1.7 дахь заалт:**

“1.6.анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах;

1.7.хэргийн зүйлчлэл, ялыг хөнгөрүүлж өөрчлөх, эсхүл прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэх.”

#### **10/39.13 дугаар зүйл:**

**“39.13 дугаар зүйл.Давж заалдах шатны шүүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх**

1.Давж заалдах шатны шүүх нь Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэг, Хорин хоёрдугаар бүлэгт заасан эрүүгийн хэргийг энэ хуулийн Гучин есдүгээр бүлэгт заасан давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг хэрэгжүүлэхгүйгээр энэ хуулийн VII хэсэгт заасан анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд хялбаршуулсан журмыг хэрэглэх хүсэлтийг хүлээн авахгүй.

3.Энэ хуульд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй бол уг хугацаа дуусмагц анхан шатны журмыг хэрэглэж хэрэг, маргааныг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ.

4.Давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан бол анхан шатны журмыг хэрэглэж хэрэг, маргааныг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гүйцэтгэнэ.

5.Дараах тохиолдлоос бусад үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн хугацаа үйлчилнэ.

5.1.Энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг дахин 15 хүртэл хоногоор сунгаж болно.

5.2.Хяналтын шатны шүүх давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх энэ хуулийн 39.2 дугаар зүйлд заасан хугацааг хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн 15 хүртэл хоногоор сунгаж болно.”

#### **11/40.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Хяналтын шатны шүүх прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэл, ялыг хөнгөрүүлж, эсхүл прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлж болно.”

#### **12/40.8 дугаар зүйлийн 1.8, 1.9 дэх заалт:**

“1.8.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах;

1.9.хэргийн зүйлчлэл, ялыг хөнгөрүүлж өөрчлөх, эсхүл прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэх.”

#### **13/40.13 дугаар зүйл:**

**“40.13 дугаар зүйл.Хяналтын шатны шүүх хэрэг, маргааныг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх**

1.Хяналтын шатны шүүх нь Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэг, Хорин хоёрдугаар бүлэгт заасан эрүүгийн хэргийг энэ хуулийн Дөчдүгээр бүлэгт заасан хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг хэрэгжүүлэхгүйгээр энэ хуулийн VIII дугаар хэсэгт заасан давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

2.Хяналтын шатны шүүх нь гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянах ба анхан шатны журмаар хэрэг хэлэлцсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 39.5 дугаар зүйлд зааснаас гадна шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарт нийцүүлж хэрэглэсэн эсэхийг хянан.

3. Давж заалдах журмаар хэрэг шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх ба уг тогтоолд гомдол гаргахгүй.

4.Давж заалдах журмаар хэрэг шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн шийдвэрийг шүүгчийн тусгай саналын хамт хэрэгт хавсаргаж, шийдвэрийн хувийг энэ хуулийн 36.13 дугаар зүйлд заасны дагуу гомдол, эсэргүүцэл гаргагчид гардуулна.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “анхан шатны шүүх”, 1.6 дахь заалтын “давж заалдах шатны шүүх гэж” гэсний дараа “Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэг, Хорин хоёрдугаар бүлэгт зааснаас бусад” гэж, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хорих ял оногдуулахаар заасан” гэсний дараа “, Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэг, Хорин хоёрдугаар бүлэгт заасан” гэж, 14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “яллагдагчийг оролцуулна.” гэсний дараа “Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг цахимаар оролцуулж болно.” гэж, 15.8 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын “шийдвэрийг өөрчлөх” гэсний дараа “, хүчингүй болгох” гэж 17.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “шийдвэрлэнэ.” гэсний дараа “Энэхүү шийдвэрт прокурор, оролцогч гомдол, эсэргүүцэл гаргаж болохгүй.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/14.9 дүгээр зүйл:**

#### **“14.9 дүгээр зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ**

1.Шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл дараахь үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

1.1.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;

1.2.шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.3 хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт

хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.4.урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид дараахь үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

2.1.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.1, 1.3-т заасан нөхцөл;

2.2.эд хөрөнгө, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа насанд хүрээгүй хүний эсрэг, эсхүл амь нас, эрүүл мэнд, бусад шалтгааны улмаас өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

2.3.зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон;

2.4.оршин байх хаяг нь тодорхойгүйн улмаас мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй.

3.Яллагдагч өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эсхүл түүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болох үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол прокурорын гаргасан саналыг үндэслэн яллагдагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.”

#### **2/14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилаагүй гэж үзвэл яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.”

#### **3/17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан шүүхийн шийдвэрт талууд, оролцогч гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно.”

#### **4/31.5 дугаар зүйл:**

##### **“31.5 дугаар зүйл.Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах**

1.Мөрдөгч сэжигтнийг дараахь тохиолдолд хойшлуулшгүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед, эсхүл эрэн сурвалжлах ажиллагааны явцад барьсан;



1.2.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн;

1.3.гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан;

1.4.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн;

1.5.хэн болох нь тогтоогдоогүй;

1.6.Монгол улсад тодорхой оршин суух хаяггүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй.

Тайлбар: Энэ зүйлийн 1.1, 1.3, 1.4-г заасан нөхцөл нь 1.2, 1.5, 1.6-д заасан нөхцөлийн аль нэг нь бий болоогүй үед дангаараа сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах үндэслэл болохгүй.

2.Мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

2.1.мөрдөгчийн тогтоолыг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

2.2.мөрдөгчийн тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл батлахаас татгалзах.

3.Прокурор яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлтэй гэж үзвэл саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, прокурорын саналыг үндэслэн яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

5.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

6.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

7.Хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

8.Хойшлуулшгүйгээр явагдсан баривчлах ажиллагааны талаар суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч шүүхэд гомдол гаргасан бол прокурор гомдлыг хянуулахаар холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

9.Шүүх гомдлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван тавдугаар бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ. Баривчлагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргавал тэднийг шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулна.”

#### **5/39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**


“4.Давж заалдах шатны шүүх прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэл, ялыг хөнгөрүүлж, эсхүл прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлж болно.”

**4 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “найман жилээс” гэснийг “арван хоёр жилээс” гэж, 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.8 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүхийн зөвшөөрөлгүй” гэснийг “хойшлуулшгүйгээр” гэж, 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Эрүүгийн хэргийг” гэснийг “Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэг, Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг таван шүүгч, бусад хэргийг” гэж, 31.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүхийн зөвшөөрөлгүй” гэснийг “Хойшлуулшгүйгээр” гэж, 34.16 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийн дугаарыг “7, 8” гэж, 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Анхан шатны шүүхийн шийдвэр” гэснийг “Анхан шатны шүүх, анхан шатны журмаар хэрэг хэлэлцсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр” гэж, мөн хэсгийн 1.2 дахь заалтын “анхан шатны шүүхийн шийдвэрийг” гэснийг “анхан шатны шүүх, анхан шатны журмаар хэрэг хэлэлцсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нэг удаа” гэснийг хассугай.

Гарын үсэг

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД



Х.НЯМБААТАР

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1-д “а/сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох талаар санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;”-ийг, “б/сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах шийдвэр бүрийн үндэслэл, шалтгааныг хэлэлцдэг шүүхийн хэлэлцүүлгийг бий болгох...эрх зүйн зохицуулалтын талаар санал боловсруулах”-ыг, “в/цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нийтлэг журам, цагдан хорих үндсэн болон сунгах хугацаа, цагдан хорих үндэслэлд хамаарах хэт ерөнхий болон өргөжүүлсэн зохицуулалт, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх асуудлыг нарийвчлан зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;”-ийг тус тус Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэж заасан.

Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пактын /цаашид “ИБУТЭТОУП” гэх/ 9 дүгээр зүйлд “1.Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.” гэж, мөн зүйлийн 3-т “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй” гэж заасан.<sup>1</sup>

<sup>1</sup> Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, 9 дүгээр зүйл 3 дахь хэсэг.

Түүнчлэн Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пактын 9 дүгээр зүйлийг тайлбарласан НҮБ-ын Хүний эрхийн хорооны 35 дугаар ерөнхий тайлбарт “баривчлах бодит үндэслэлийг хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай бөгөөд хэт өргөн агуулгатай зохицуулалт тусгах нь хүний эрхийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлдэг” гэжээ.

## **1.2. Практик шаардлага**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

### **Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагааны талаар:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болох тохиолдлыг, 31.4 дүгээр зүйлд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэйгөөр баривчлах үндэслэлийг хуульчилсан.

Шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулсан судалгааг<sup>2</sup> сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2020 онд 793 буюу 99.3 хувь, 2021 онд 809 буюу 98.5 хувь, 2022 онд 1075 буюу 99.7 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явагдсан байна. Энэ талаар Хүний эрхийн үндэсний комиссын /цаашид “ХЭҮК” гэх/ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэл<sup>3</sup> болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд<sup>4</sup> тодорхой дурджээ.

Ийнхүү сэжигтнийг баривчлах ажиллагааны 98-99 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй явуулж буй өнөөгийн нөхцөл байдлаас харахад Монгол Улсад баривчлах ажиллагаа үндсэндээ шүүхийн хяналтаас гадуур хэрэгжиж байна.

Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлүүдийг 2020-2022 оны байдлаар авч үзвэл, нийт баривчлах ажиллагааны 60-аас дээш хувийг “хойшлуулшгүй тохиолдолд” гэсэн үндэслэлээр баривчилсан байна<sup>5</sup>.

Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад, үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдол 2020 онд 448 буюу 56.4 хувь, 2021 онд 496 буюу 61.3 хувь, 2022 онд 595 буюу 55.5 хувийг тус тус эзэлж байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтний 42.1 орчим хувийг 24-48 цаг хорьсны дараа суллажээ<sup>6</sup>.

“Хойшлуулшгүй тохиолдол” гэх хууль зүйн ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.26-д “хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөвөөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг”

<sup>2</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 4/1750 дугаар албан бичиг

<sup>3</sup> <https://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/>

<sup>4</sup> НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр.

<sup>5</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/311 дүгээр албан бичиг.

<sup>6</sup> Мөн тэнд.



ойлгохоор аутентик тайлбар хийгдсэн нь хойшлуулшгүй журмаар явагдах баривчлах ажиллагааны үндэслэлийг бүрэн, оновчтой илэрхийлж чадахгүй байна.

Түүнчлэн ХЭҮК-ын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэлд дурдсанаар нийт баривчилсан 382 хүнээс “Гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан” гэх үндэслэлийг дангаар нь хэрэглэж 135 хүнийг баривчилсан боловч 24-48 цагийн дараа үндэслэл тогтоогдоогүй гэх шалтгаанаар суллажээ.

Энэ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хор уршиг болон сэжигтэнд оногдуулж болох ялын төрөл, хэмжээг үл харгалзан баривчлах боломжийг олгосон эрх зүйн зохицуулалт, нөгөө талаар мөрдөн шалгах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч албан тушаалтны субъектив хандлагаас хамаарч харилцан адилгүй хэрэглэх боломжтойг харуулж байна гэж ХЭҮК дүгнэсэн байдаг.

Иймд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулахад практикт хамгийн их хэрэглэгддэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.2-т заасан “хойшлуулшгүй тохиолдол” болон мөн хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх заасан сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах бусад үндэслэлийг тодорхой болгон нарийвчлан хуульчлах шаардлага үүсээд байна.

НҮБ-ийн Дур зоргоор саатуулах асуудал эрхэлсэн хорооны гаргасан урьдчилсан дүгнэлтэд “сэжигтэн, яллагдагч мэдүүлэг авах ажиллагаанаас гарах эрхгүй буюу мөрдөгчийн хяналтад орсон цаг мөчөөс эхлэн саатуулагдсан гэж үзнэ” гэж тусгажээ. Олон улсын сайн туршлагаас харахад баривчилсан сэжигтнийг шүүхэд хүргэх хугацааг нарийвчлан зааснаас гадна уг хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг, мөн хугацааг тодорхой заагаагүй боловч даруй, шаардлагагүй хугацаа алдахгүйгээр хамгийн ойр байгаа шүүхэд, эсхүл захиргааны ажилтанд хүлээлгэж өгөхөөр хуульчилж байгаа нь хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой байна.

Иймд баривчлах хугацаа дуусахаас өмнө мөрдөгч, прокурор саналаа, сэжигтний хамт шүүхэд хүргүүлэх хугацааг хуульд тодорхой зааж, шүүхийн анхны хэлэлцүүлэгт сэжигтнийг биечлэн оролцох боломжийг хуульд баталгаажуулах шаардлагатай байна.

Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэлд дурдсанаар сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа 2020 онд 798 хийгдсэнээс шүүх 178 буюу 22.3 хувь, 2021 онд 821 баривчилгаа хийгдсэнээс 19.6 хувь нь шүүхээр хянагдсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй.” гэж заасан хэдий ч шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдаж, суллагдсан хүн баривчлах ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмыг мөн хуулийн 35.1 дүгээр зүйлд тухайлан хуульчлаагүй байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх зорилгоор сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаанд

тавих шүүхийн хяналтыг сайжруулах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

**Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын талаар:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тухайлан хуульчлаагүй бөгөөд практикт гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүхээр, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагын буюу хэргийн харьяаллаар, эсхүл тагнуул, авлигатай тэмцэх газрын харьяаллын хэрэгт хяналт тавьж буй прокурорын байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллаар баривчлах, цагдан хорих асуудлыг шүүх хянан шийдвэрлэж байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нь зарим тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ” гэсэн нийтлэг зарчимд нийцэхгүйгээс гадна сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих зөвшөөрөл олгох шүүхийн харьяаллыг шүүхийн практикт өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх, хэргийн оролцогч шүүхийн харьяалалтай холбогдуулан шүүгч, шүүхээс татгалзан гаргах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учрах нөхцөл байдлыг бий болгож байна.

Түүнчлэн тусгай харьяаллын мөрдөн шалгах байгууллагаас гаргасан саналыг Нийслэлийн дүүргүүдээс зөвхөн нэг шүүх харьяалан шийдвэрлэх нь оролцогчдын шүүмжлэл, хардлагыг дагуулж байгаа юм.

Анх гаргасан гомдол, мэдээллийн дагуу баривчлах ажиллагаа явуулах үед Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан эрүүгийн хэрэгт нотолбол зохих ажиллагаа бүрэн гүйцэд хийгдээгүй, сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүх тогтоогоогүй байдаг.

Иймд ИБУТЭТОУП-ын 9 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу баривчлагдсан сэжигтний шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд, шуурхай хангах шаардлагыг харгалзан, сэжигтэнд баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхой болгох шаардлагатай байна.

**Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих ажиллагаанд шүүхийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх талаар:**

Сэжигтнийг баривчлах ажиллагаа нь мөрдөн шалгах ажиллагаанд учирч болзошгүй бодит эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор явагддаг бөгөөд хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй хийгддэг.

Сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахад практикт амралтын өдрүүд тохиоход шүүхээр шийдвэрлүүлэхэд хүндрэл үүсэж, үүнээс улбаатай ялангуяа сэжигтнийг баривчлах хугацаа хэтэрч байгаа тохиолдол гарч байна.

Иймд сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг ажлын цагаар хязгаарлахгүйгээр, тасралтгүй хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

## **Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар:**

Яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах зарим үндэслэл нь хэт ерөнхий байгаа нь субъектив шинжтэй байгааг анхаарч цагдан хорих үндэслэлийн объектив шалгуурыг нарийвчлан тодорхой болгон хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацааг хуульчлахдаа хугацаа сунгах журмыг гүйцэд зохицуулаагүй байна. Прокуророос яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах саналаа “хугацаа дуусах өдөр, цагийг”-ийг тулгаж шүүхэд ирүүлдэгээс үүдэн шүүхийн практикт хэлэлцүүлгийг товлон зарлах, бусад оролцогчийг дуудан ирүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал цөөнгүй үүсэж байна.

Шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэх нь олон жил шүүхийн практикт маргаан дагуулж ирсэн. Тодруулбал, шүүхийн шатанд буюу шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаанд хамаарах эсэхийг тусгайлан хуульчлаагүй болно.

Анхан шатны шүүхийн шүүгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд зааснаар прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх, мөн хуулийн 33.2 дугаар зүйлд зааснаар яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж эхлэх үүрэгтэй бөгөөд дээрх зохицуулалтын хүрээнд шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа тодорхойлогдож байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэхээр хуульчилсан бөгөөд мөн хуулийн 36.11 дүгээр зүйлд зааснаар шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, ял оногдуулахгүйгээр тэнссэн, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллахаар заасан тул шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болтол цагдан хорих арга хэмжээ авагдсан шүүгдэгчийн хувьд дээрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд түүний цагдан хоригдох хугацаа тоологдож байна.

Иймд шүүгдэгчийг цагдан хорих хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэхийг тодорхой хуульчлах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн шийдвэрийг прокурор, оролцогч эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг мөн зүйлийн 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт

зааснаар тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл түүний эзгүйд томилогдсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ гэж заажээ.

Гэвч Ерөнхий шүүгч, эсхүл түүний эзгүйд томилогдсон шүүгч гомдлыг хянаад хүчингүй болгох эрх хэмжээг мөн зүйлийн 5 дахь хэсэгт хуульчлаагүй орхигдуулсан байх тул шүүхийн практикт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон төсөөтэй хэрэглэж байна

### **Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний талаар:**

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхэд шууд нөлөөлөх нэг хүчин зүйл нь хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг нэмэгдүүлэх, уг арга хэмжээнд тавих техникийн хяналтыг сайжруулах явдал бөгөөд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

**Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд учирч буй асуудлын талаар:**

Улсын Их Хурлаас баталсан 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаас эрүүгийн хэргийг прокурорт буцаах шүүхийн эрх хэмжээг хүчингүй болгохдоо давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээг хамтад нь хүчингүй болгосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зарим алдааг зөвтгөх хууль зүйн боломжгүй нөхцөл байдлыг бий болгоод байна.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс дээрх хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд дараах асуудлууд шүүхийн практикт бодитой тулгараад байна.

1. Давж заалдах шатны зарим шүүх анхан шатны шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцээгүй, Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн алдааг илрүүлсэн боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар давж заалдах шатны шүүх нь хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхгүй болсон гэж дүгнэн, анхан шатны шүүхийн хуульд нийцээгүй шийдвэрүүдийг хэвээр үлдээн шийдвэрлэж байна.

Тухайлбал, хууль бус бүрэлдэхүүнээр хэрэг шийдвэрлэсэн, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг үндэслэлгүйгээр прокурорт буцаасан, түүнчлэн хэргийн зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлсэн, эсхүл хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж ял завшуулсан зэрэг анхан шатны шүүхийн гаргасан хууль хэрэглээний ноцтой алдааг илрүүлж, энэ талаар оролцогчийн гаргасан давж заалдах гомдол, прокурорын бичсэн эсэргүүцэл хууль зүйн үндэслэлтэй талаар дүгнэлт хийсэн атлаа тухайн алдаа зөрчлийг зөвтгүүлэх зорилгоор давж заалдах шатны шүүх хэргийг анхан шатны шүүхэд буцааж, хэргийг дахин хэлэлцүүлэх эрхгүй гэж дүгнэн холбогдох



шийдвэрүүдийг хэвээр үлдээж буй нь Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт, нийтлэг зарчмууд болон уг хуулийн бусад хэм хэмжээтэй илтэд зөрчилдөж байгаа юм.

2. Анхан шатны шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, эсхүл шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн алдааг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас тогтоосон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасны дагуу тухайн шийдвэрийг хүчингүй болгохоор хуульчлан заасан бөгөөд шүүхэд үүрэг болгосон энэхүү хэм хэмжээ өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэтэл давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хүчингүй болгохдоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн зөвтгөх, дутуу хийгдсэн мөрдөн шалгах ажиллагааг нөхөн гүйцэтгэх зохицуулалтыг хуульчлахгүй орхигдуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх, эсхүл цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгосон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ямар журмаар үргэлжлүүлэн явуулахыг хуульд заагаагүй орхигдуулсан тул давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ийнхүү шийдвэрлэсэн хэргийг цаашид хэрхэх нь тодорхойгүй нөхцөл байдал үүсээд байна.

Учир нь, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд зааснаар давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй, тогтоогоогүй нөхцөл байдал, шинжлэн судлаагүй нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгох буюу шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзвэл хэргийн үйл баримтыг шинээр өөрчлөн тогтоох, түүнд үндэслэн хэргийн зүйлчлэл болон ялыг хүндрүүлэн өөрчлөх эрх хэмжээ олгогдоогүй юм.

Хяналтын шатны шүүхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлд зааснаар анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянах зэрэг үндэслэлээр эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх эрх хэмжээг хуульчлан тогтоосон боловч ийнхүү хэргийг хянахдаа анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдоогүй, эсхүл үгүйсгэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, түүнийг нотлогдсон гэж үзэх, ямар нэг нотлох баримтыг нөгөөгөөс нь ач холбогдолтойд тооцох, анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, ямар ял оногдуулах тухай асуудлыг урьдчилан шийдвэрлэх эрхгүйгээс гадна шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан, өөрөөр хэлбэл хэргийн зүйлчлэл болон ялын төрөл, хэмжээг хүндрүүлсэн байдлаар хэргийг эцэслэн шийдвэрлэх эрхгүй байна.

Дээрх нөхцөл байдлууд нь шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хуулийг буруу хэрэглэсэн алдаа зөрчлийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар илрүүлсэн тохиолдолд тухайн хэргийг доод шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх замаар уг алдааг зөвтгүүлж, гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэлийг хүлээлгэх, хохирогчийн болон нийтийн эрх ашгийг нөхөн сэргээж

шударга ёсыг тогтоох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй, цаашилбал гэм буруутай этгээд ял завших, улмаар шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах иргэний эрх ноцтой зөрчигдөх нөхцөл байдлыг бий болгож байна.

### **Шүүх хуралдаан хойшлохтой холбоотой асуудлын талаар:**

Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг.

Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох нь яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийн нэг юм.

Гэтэл практикт эрүүгийн хэргийн зарим оролцогч өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэтрүүлэн эдэлж, өмгөөлөгчөөсөө татгалзах, шинээр өмгөөлөгч авах, нэмж өмгөөлөгч авах зэргээр шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж, оролцогчдод чирэгдэл үүсгэх явдал гарсаар байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.” гэж заасан нь шүүх хуралдааныг хойшлогдох явдлыг багасгахад чиглэсэн хэм хэмжээ боловч өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй, шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзсан, шинээр өмгөөлөгч авах хүсэлт гаргасан тохиолдолд түүний өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хангах нь өнөөгийн шүүхийн практикт тулгамдсан асуудал хэвээр байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах нь хүн хилсээр ял шийтгэгдэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдах чухал баталгаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна.” гэж заасан нь мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан заавал өмгөөлөгчтэй явуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарч байх тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд өмгөөлөгч томилон оролцуулж, шүүх хуралдааныг тасралтгүй явуулах нөхцөлийг хангах шаардлагатай.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан иргэний “хууль зүйн туслалцаа авах” эрхийг баталгаатай хангах, Арван есдүгээр зүйлийн 1-д заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд шүүгдэгч өмгөөлөгч авахаас татгалзсан, эсхүл шүүх хуралдаанд өмгөөлөгч нь ирээгүй тохиолдолд өмгөөлөгч томилж оролцуулах журмыг тодорхой болгон хуульчлах шаардлагатай байна.

### **Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлын талаар:**

Шүүхийн сахилгын хорооноос 2022-2023 онд нэр бүхий 28 шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийн үндэслэлийг судалж үзэхэд Шүүхийн сахилгын хороо нь өргөдөл, мэдээллийн дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчид сахилгын шийтгэх оногдуулах эсэх асуудлыг шийдвэрлэхдээ шүүгчийн хууль хэрэглэсэн мэргэжлийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх шаардлага үүсэж байгаа нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн бүрэн эрх, чиг үүрэгтэй давхцаж байгаагаас гадна шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүний дотор хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль тайлбарлаж гаргасан шийдвэрийн талаар Шүүхийн сахилгын хорооны хийсэн дүгнэлтийг тухайн зөрчилд холбогдсон шүүгч хүлээн зөвшөөрөхгүй, үндэслэлтэйгээр маргах явдал цөөнгүй гарсан байна.

Иймд Шүүхийн сахилгын хороо болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн чиг үүргийн давхардлыг арилгаж, шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийн илт тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, эсхүл удаа дараа зөрчсөн талаар дээд шатны шүүхээс хийсэн хууль зүйн дүгнэлт болон зөрчил гаргасан шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэн шалгуулах тухай дээд шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн Шүүхийн сахилгын хороо тухайн зөрчил гаргасан шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэдэг байх өөрчлөлтийг хуульчлах шаардлагатай байна.

#### **Авлигын гэмт хэргийг шүүх хянан шийдвэрлэх талаар:**

Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд нэн тэргүүнд цаг алдахгүй, түргэн шуурхай байдлыг хангах, нөгөөтэйгүүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөх болон прокурорын байгууллага дагнасан байгааг харгалзан шүүхийн шатанд ч мэргэжил, туршлагын ахиу түвшний бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай нь авлигын ерөнхий нөхцөл байдал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэх үеэр тогтоогдсон байна.

Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх хараат бус, хариуцлагатай, мэргэшсэн, иргэдийн итгэл хүлээсэн шүүгч, шүүхийн тогтолцоог бий болгож бэхжүүлэхэд дагнасан шүүх байгуулахаас илүүтэйгээр шүүхийн ердийн тогтолцоонд тулгуурласан боловч шүүгчдийн ур чадвар, туршлага бүхий хэсгээс шүүх бүрэлдэхүүнийг бүрдүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цөөн шат, дамжлагатай шийдвэрлэх замыг сонгох нь бусад хувилбартай харьцуулвал сөрөг үр дагавар багатайгаар зарим давуу талыг бий болгох боломжтой байна.

Манай улсын хувьд тодорхой төрлийн гэмт хэргийг үр дүнтэй, богино хугацаанд, шударга ёсыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэдэг тогтолцоог эрэлхийлж буйн хувьд өөрийн уламжлалт туршлагад тулгуурлаж Германы загварыг хэргийн төрлөөр хязгаарлан хумьж хялбаршуулсан буюу авлигын гэмт хэргийг бүх давж заалдах шатны шүүх, эсхүл хэргийн ачааллаас хамааран зөвхөн Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хэлэлцэж Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим давж заалдах журмаар хэлэлцдэг тогтолцоон дээр тогтож болохоор байна.

**Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох талаар:**

Шүүхийн нэгдсэн мэдээнээс үзэхэд анхан шатны шүүхүүд 2020-2022 онд 47440 хүнд холбогдох 39735 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэснээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт заасан тусгай журмын дагуу хялбаршуулсан журмаар 15347 хүнд (32.3 хувь) холбогдох 14016 хэргийг (35.3 хувь) хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс 49.6 хувь буюу 6949 хэргийг нийслэлд, 50.4 хувь буюу 7067 хэргийг орон нутагт тус тус хянан шийдвэрлэжээ.

Гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн хүнд холбогдох хэргийг богино хугацаанд хянан хэлэлцэж шийдвэрлэх нь нэг талаас хэргийн оролцогчийн эрхийг хангах, хохирогч талын зөрчигдсэн эрхийг шуурхай сэргээн эдлүүлэх, нөгөө талаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болон цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой.

Иймд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг харгалзан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д заасан иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад хамаарах асуудлыг зохицуулсан хуулийн төсөл болно.

### **Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал, сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа сунгах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлөгчөөр хангах , хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зохицуулалт;

-Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах, прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэн хэргийн зүйлчлэл, ялыг өөрчлөхгүйгээр ялыг хүндрүүлж болох, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан ажиллагааг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор хойшлуулахтай холбоотой зохицуулалт;

-Авлигын гэмт хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, хяналтын шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тус тус нэмнэ.



Хуулийн төслийн 2 дугаар зүйлд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн өмнөх шатанд прокурор шийдвэрлэх, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг хянан хэлэлцэх анхны хэлэлцүүлэгт яллагдагчийг биечлэн оролцуулж, түүний “шүүхэд мэдүүлэх эрх”-ийг хангахтай холбоотой өөрчлөлтийг тусгана.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэлийг тодорхой болгох, уг ажиллагаанд тавих шүүхийн хяналт, зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгана.

Хуулийн төслийн 4, 5 дугаар зүйлд нэр томьёо, хууль зүйн техниктэй холбоотой өөрчлөлтийг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрх улам бүр баталгаажиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцнэ.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болсноор хүний эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшилнэ.

Авлигын гэмт хэргийг түргэн шуурхай, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хууль төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх техник, тоног төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэхтэй холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт болон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжид нийцүүлж, Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг харгалзан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д заасан иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад хамаарах асуудлыг зохицуулсан хуулийн төсөл болно.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

### **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 31.5 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН СЭЖИГТНИЙГ ШҮҮХИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ БАРИВЧЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙД:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлд заасан “Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах” ажиллагааг “Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах” гэж өөрчилсөн.

Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа нь гэмт хэрэгт сэрдэгдсэн хүнийг оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх, эсхүл гэмт хэргээ төгс үйлдэх, нотлох баримтыг устгах, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах аливаа эрсдэлээс хамгаалахад чиглэдэг.

Шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулсан судалгааг<sup>1</sup> сүүлийн 3 жилийн байдлаар судалж үзэхэд 2020 онд 793 буюу 99.3 хувь, 2021 онд 809 буюу 98.5 хувь, 2022 онд 1075 буюу 99.7 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явагдсан байна. Энэ талаар Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэл<sup>2</sup> болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд<sup>3</sup> тодорхой дурджээ.

Ийнхүү сэжигтнийг баривчлах ажиллагааны 98-99 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй явуулж буй өнөөгийн нөхцөл байдлаас харахад Монгол Улсад баривчлах ажиллагаа үндсэндээ шүүхийн хяналтаас гадуур хэрэгжиж байна.

<sup>1</sup> Улсын Ерөнхий прокурорын газрын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 4/1750 дугаар албан бичиг

<sup>2</sup> <https://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/>

<sup>3</sup> НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр.

1. Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэлд дурдсанаар нийт баривчилсан 382 хүнээс “Гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан” гэх үндэслэлийг дангаар нь хэрэглэж 135 хүнийг баривчилсан боловч 24-48 цагийн дараа үндэслэл тогтоогдоогүй гэх шалтгаанаар суллажээ.

Энэ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хор уршиг болон сэжигтэнд оногдуулж болох ялын төрөл, хэмжээг үл харгалзан баривчлах боломжийг олгосон эрх зүйн зохицуулалт, нөгөө талаар, мөрдөн шалгах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч албан тушаалтны субъектив хандлагаас хамаарч харилцан адилгүй хэрэглэх боломжтойг харуулж байна гэж ХЭҮК дүгнэсэн байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан “гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан”, 1.3-т заасан “гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан”, 1.4-т заасан “тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн” зэрэг сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэлүүдийн шинжийг өргөжүүлж, нарийвчлан тусгалаа.

Ийнхүү сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлсоноор практикт баривчлах үндэслэлийг субъектив хандлагаас хамаарч харилцан адилгүй хэрэглэж байгаа асуудлыг нэг мөр зохицуулах ач холбогдолтой юм.

2. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлүүдийг 2020, 2021, 2022 оны байдлаар авч үзвэл, нийт баривчлах ажиллагааны 60-аас дээш хувийг “хойшлуулшгүй тохиолдолд” гэсэн үндэслэлээр баривчилсан байна<sup>4</sup>.

Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдол 2020 онд 448 буюу 56.4 хувь, 2021 онд 496 буюу 61.3 хувь, 2022 онд 595 буюу 55.5 хувийг тус тус эзэлж байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтний 42.1 орчим хувийг 24-48 цаг хорьсны дараа суллажээ<sup>5</sup>.

“Хойшлуулшгүй тохиолдол” гэх хууль зүйн ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.26-д “хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг” ойлгохоор аутентик тайлбар хийгдсэн нь хойшлуулшгүй журмаар явагдах баривчлах ажиллагааны үндэслэлийг бүрэн, оновчтой илэрхийлж чадахгүй байна.

Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт(ИБУТЭТОУП)-ын 9 дүгээр зүйлийг тайлбарласан НҮБ-ын Хүний эрхийн хорооны 35 дугаар ерөнхий тайлбарт баривчлах бодит үндэслэлийг хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай бөгөөд хэт өргөн агуулгатай зохицуулалт тусгах нь хүний эрхийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлдэг гэжээ.

---

<sup>4</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02/311 дүгээр албан бичиг.

<sup>5</sup> Мөн тэнд.

Иймд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулахад практикт хамгийн их хэрэглэгддэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “хойшлуулшгүй тохиолдол” гэх үндэслэлийг “өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн” гэж шинжийг өргөжүүлж, нарийвчлан тусгалаа.

Ингэснээр мөрдөгч хойшлуулшгүй тохиолдлын аль үндэслэлээр шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулсан талаар шийдвэртээ тодорхой дурдах хууль зүйн шаардлага бий болно гэж үзсэн болно.

3.Гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүний талаар “хэн болох нь тогтоогдоогүй; Монгол улсад тодорхой оршин суух хаяггүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;” зэрэг тухайн хүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй нөхцлийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэлд нэмэхээр тусгалаа.

Түүнээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4-т заасан гэмт хэрэгт сэрдэгдэх объектив шалгуур нь дангаараа тухайн хүнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэл болохгүй бөгөөд хуульд заасан нэмэлт нөхцөл бий болсон үед уг арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульд аутентик тайлбар хийх нь шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагааг хязгаарлана гэж үзэж байна.

НҮБ-ийн Дур зоргоор саатуулах асуудал эрхэлсэн хорооны гаргасан урьдчилсан дүгнэлтэд “сэжигтэн, яллагдагч мэдүүлэг авах ажиллагаанаас гарах эрхгүй буюу мөрдөгчийн хяналтад орсон цаг мөчөөс эхлэн саатуулагдсан гэж үзнэ” гэж тусгажээ. Олон улсын сайн туршлагаас харахад баривчилсан сэжигтнийг шүүхэд хүргэх хугацааг нарийвчлан зааснаас гадна уг хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг, мөн хугацааг тодорхой заагаагүй боловч даруй, шаардлагагүй хугацаа алдахгүйгээр хамгийн ойр байгаа шүүхэд, эсхүл захиргааны ажилтанд хүлээлгэж өгөхөөр хуульчилсан нь хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Иймд сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагаанд прокурор хяналт тавьж, мөрдөгчийн тогтоолыг баталж, шүүхэд даруй хүргүүлэх, эсхүл тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл батлахаас татгалзах тухай шийдвэр гаргах зохицуулалтыг тусгалаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд манай улсад 2020-2021 онд хийгдсэн баривчлах ажиллагааны 98-99 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй хийгдсэн, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг үр дүнгүй явагддаг талаар онцолсон байна. Түүнчлэн ХЭҮК-ийн хийсэн судалгаагаар 2020-2022 онд нийт 2,694 хүн баривчлагдсаны 2,674 буюу 99 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр саатуулагджээ.

Иймд шүүхийн зөвшөөрөлгүй явагдсан баривчлах ажиллагаанд шүүхийн хяналтыг сайжруулах зорилгоор сэжигтнийг баривчилснаас хойш шүүх 24 цагийн дотор



мөрдөгчийн шийдвэрийг хянан хэлэлцэж, сэжигтнийг суллах, эсхүл үргэлжлүүлэн цагдан хорих зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ шүүхийн зөвшөөрөлгүй явагдсан баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох буюу уг ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг дүгнэж, цаашид прокурорын саналын дагуу яллагдагчийг үргэлжлүүлэн цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх, хууль бусаар хоригдсон (эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах үндэслэл тогтоогдоогүй) бол түүнийг суллах асуудлыг хамтад нь шийдвэрлэхийг тодорхой болгох шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 1.4 дүгээр зүйлийн 1.34 дэх заалтад *“прокурорын шийдвэр” гэж Прокурорын тухай хуулийн 31.1-д заасныг;...ойлгоно.* гэж, Прокурорын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт *“...Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тогтоол, даалгавар, зөвшөөрөл, шаардлага, мэдээгдэл, дүгнэлт, санал, эсэргүүцэл, хүсэлт, нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана.”* гэж тус тус заасан.

Иймд шүүх хойшлуулшгүйгээр баривчлагдсан яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэдэг байх зохицуулалтыг тусгалаа.

Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь удаагийн илтгэлд дурдсанаар сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа 2020 онд 798 хийгдсэнээс шүүх 178 буюу 22.3 хувь, 2021 онд 821 баривчилгаа хийгдсэнээс 19.6 хувь нь шүүхээр хянагдсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй.”* гэж заасан хэдий ч шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдаж, суллагдсан хүн баривчлах ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмыг мөн хуулийн 35.1 дүгээр зүйлд тухайлан хуульчлаагүй байна.

Иймд хойшлуулшгүйгээр явагдсан баривчлах ажиллагааны талаар суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч шүүхэд гомдол гаргасан бол прокурор баривчлах ажиллагаа явуулах болсон үндэслэл, уг ажиллагааны үр дүн, гомдлыг хянуулахаар холбогдох материалыг харьяалах шүүхэд хүргүүлдэг байх зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү шүүхийн зөвшөөрөлгүй явагдсан баривчлах ажиллагааны үндэслэл, үр дүнг хянуулахаар холбогдох материалыг шүүхэд хүргүүлснээр баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх чухал механизм болно гэж үзсэн болно.

## **БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АСУУДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ХАРЬЯАЛЛЫН ТАЛААР:**

### **2.2 дугаар зүйл: Шүүхийн харьяалал**

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тухайлан хуульчлаагүй бөгөөд практикт гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүхээр, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагын буюу хэргийн харьяаллаар, эсхүл тагнуул, авлигатай тэмцэх газрын харьяаллын хэрэгт хяналт тавьж буй прокурорын байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллаар баривчлах, цагдан хорих асуудлыг шүүх хянан шийдвэрлэж байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нь зарим тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ” гэсэн нийтлэг зарчимд нийцэхгүйгээс гадна сэжигтнийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох шүүхийн харьяаллыг шүүхийн практик өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх, оролцогч шүүхийн харьяалалтай холбогдуулан шүүгч, шүүхээс татгалзан гаргах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учрах нөхцөл байдлыг бий болгож байна.

Түүнээс гадна тусгай харьяаллын мөрдөх байгууллагаас гаргасан саналыг Нийслэлийн дүүргүүдээс зөвхөн нэг шүүх харьяалан шийдвэрлэх нь оролцогчдын шүүмжлэл, хардлагыг дагуулж байгаа юм.

Анх гомдол, мэдээллийн дагуу баривчлах ажиллагаа явуулах үед Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан эрүүгийн хэрэгт нотолбол зохих ажиллагаа бүрэн гүйцэд хийгдээгүй, сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүх тогтоогоогүй байдаг.

ИБУТЭТОУП-ын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй” гэж заасан.<sup>6</sup>

Иймд сэжигтэнд баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тодорхой болгож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчилсан зохицуулалтыг тусгалаа. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тохиолдолд прокурорын саналыг гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүх, эсхүл сэжигтний оршин байгаа газрын шүүх хянан шийдвэрлэх талаар холбогдох нэмэлтийг тусгалаа. Харин хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, эсхүл тухайн баривчлах ажиллагаа явагдсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэхээр нэмж тусгалаа.

Түүнчлэн Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга

---

<sup>6</sup> Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, 9 дүгээр зүйл 3 дахь хэсэг.

хэмжээ авах тухай прокурорын саналыг тухайн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэх нэмэлтийг тусгалаа.

Ийнхүү сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг нарийвчлан тогтоосноор сэжигтэн, яллагдагчийн шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд, шуурхай хангах боломж бүрдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид хэвийн явагдах нөхцөл хангагдах юм.

## **БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫГ ТАСРАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР:**

### **3.1 дүгээр зүйл.Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх**

Сэжигтнийг баривчлах ажиллагаа нь мөрдөн шалгах ажиллагаанд учирч болзошгүй бодит эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор явагддаг бөгөөд хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй хийгддэг.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх хуралдааныг өдрийн цагаар явуулах ба амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.” гэсэн заалттай уялдуулан шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг ажлын цагаар хязгаарлахгүйгээр, хуанлийн өдөрт, өдрийн цагаар тасралтгүй хэрэгжүүлэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3 дахь хэсэгт заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг мөн шүүх тасралтгүй хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Ингэснээр сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахад практикт амралтын өдрүүд тохиоход шүүхээр шийдвэрлүүлэхэд хүндрэл үүсэж, үүнээс улбаатай ялангуяа сэжигтнийг баривчлах хугацаа хэтэрч байгаа тохиолдлыг шийдвэрлэнэ гэж үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор, дээрх шүүхийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх журмыг Улсын дээд шүүх батлах тухай зохицуулалтыг тусгалаа.

## **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 14.9 ДҮГЭЭР ЗҮЙЛД ЗААСАН ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙД:**

Олон улсын сайн туршлагыг харгалзан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлж болох (эсхүл хорих ялын дээд хэмжээг 3 жилээс доош хугацаагаар тогтоосон) гэмт хэрэг үйлдсэн хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хязгаарлах зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар тусгаж, мөн зүйлд заасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлд дараахь нэмэлт, өөрчлөлтийг тусгалаа.

Ингэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.2-т заасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ үндэслэлээс “Яллагдагч

өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах” гэсэн үндэслэлийг тусад нь яллагдагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болгож “3.Яллагдагч өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эсхүл түүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болох” гэж;

мөн зүйлийн 1.3-т заасан “гэмт хэрэг үйлдэж болзошгүй” гэсэн хэт ерөнхий шалгуурыг “хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх” гэж объектив шалгуурыг нарийвчлан тодорхойлж, нэмэлт, өөрчлөлтийг тусгалаа.

#### **14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан.

Ийнхүү яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь прокурор, шүүгчийн үлэмжээс хамаарах буюу хэт субъектив шинжтэй байх тул шалгуурыг объектив байдлаар нарийвчлан тодорхойлж холбогдох зохицуулалтыг тусгалаа. Өөрөөр хэлбэл, “яллагдагчийн хувийн байдал” гэх субъектив шалгуурыг өөрчлөн объектив үндэслэлүүдийг тодорхойлсон.

#### **14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол” гэсэн хууль зүйн үндэслэлийг тодорхой болгох өөрчлөлтийг тусгалаа.

“Хэргийн ээдрээ төвөгтэй байдал”, “цагдан хорих зайлшгүй шаардлага” гэх нөхцөлүүд нь субъектив шинжийг агуулсан байх тул үүнийг “шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилаагүй гэж үзвэл” гэх объектив шалгуураар сольж өөрчлөн тусгалаа.

#### **14.10 дугаар зүйлд 7, 8 дахь хэсэг нэмэх тухай:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг хуульчлахдаа хугацаа сунгах журмыг гүйцэд зохицуулаагүй орхигдуулсан.

Иймд мөрдөгч яллагдагчийг үргэлжлүүлэн цагдан хорих тухай саналаа хугацаа дуусахаас 5 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх, прокурор цагдан хорих хугацааг сунгах

тухай саналаа даруй шүүхэд хүргүүлэх, шүүх прокурорын саналыг хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргах зохицуулалтыг нэмж тусгалаа.

Ийнхүү цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах процессыг нарийвчлан тодорхойлсноор прокуророос яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах саналаа “хугацаа дуусах өдөр, цагийг”-ийг тулгаж шүүхэд ирүүлснээс болж шүүхийн практикт хэлэлцүүлгийг товлон зарлах, бусад оролцогчийг дуудан ирүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг явдлыг хязгаарлах ач холбогдолтой юм.

#### **14.10 дугаар зүйлд 9 дэх хэсэг нэмэх тухай:**

Шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэх нь олон жил шүүхийн практикт маргаан дагуулж ирсэн тул энэ асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэх бөгөөд яллагдагчаар татах тогтоол үйлдсэн үеэс эхлэн хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор мөрдөн байцаалтын ажиллагаа авагддаг билээ.

Мөрдөн байцаалтын ажиллагааг хэвийн явуулах зорилгоор яллагдагчийг цагдан хорих үндэслэл, хугацаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, сунгах журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9, 14.10, 14.13 дугаар зүйлд нарийвчлан зохицуулсан.

Хууль тогтоогч гэмт хэргийн ангилал, төрлөөс хамаарч яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгаж болох дээд хэмжээг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялгамжтай тогтоосноос гадна мөн хуулийн 14.11 дүгээр зүйлд өсвөр насны яллагдагч, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй яллагдагч, жирэмсэн яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглох үндэслэл, мөн хуулийн 18.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өсвөр насны яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгаж болох дээд хэмжээг насанд хүрэгсдээс багаар тогтоосон болно.

2. Хууль тогтоогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт цагдан хорих үндсэн хугацаа, түүнийг сунгаж болох дээд хэмжээг хуульчлан батлахдаа мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно” гэж хуульчлан заажээ.

Харин шүүхийн шатанд буюу шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасны дагуу яллагдагчид авсан

цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хязгаарлалтад хамаарах эсэхийг тусгайлан хуульчлаагүй болно.

Анхан шатны шүүхийн шүүгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дугаар зүйлд зааснаар прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх, мөн хуулийн 33.2 дугаар зүйлд зааснаар яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж эхлэх үүрэгтэй бөгөөд дээрх зохицуулалтын хүрээнд шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа тодорхойлогдож байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэхээр хуульчлагдсан бөгөөд мөн хуулийн 36.11 дүгээр зүйлд зааснаар шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, ял оногдуулахгүйгээр тэнссэн, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллахаар заасан тул шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болтол цагдан хорих арга хэмжээ авагдсан шүүгдэгчийн хувьд дээрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд түүний цагдан хоригдох хугацаа тоологдоно.

Хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгах журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 2, 39.2 дугаар зүйлийн 2, 40.3 дугаар зүйлд тус тус тусгайлан хуульчилсныг дурдах нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно” заасан бөгөөд мөрдөн байцаалтын шатанд яллагдагчийг цагдан хорих, эсхүл цагдан хорих хугацааг сунгасан шүүгчийн шийдвэрийг прокурор, оролцогч эс зөвшөөрвөл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй байдаг.

Шүүхийн шатанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, түдгэлзүүлэх, хэргийг прокурорт буцаах, харъяалах шүүхэд шилжүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах тохиолдол бүрд шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэхийг давхар шийдвэрлэх шаардлага үүсдэг бөгөөд ийнхүү шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэрт гомдол гаргах, гаргасан гомдлыг нь хэлэлцэн шийдвэрлэх журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан хуульчлаагүй.

Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.10 дугаар зүйлд “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно”, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.4-т “шүүгдэгч нь шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хугацааг ял оногдуулахдаа хэрхэн тооцсон”-ыг заах, мөн хуулийн 39.10 дугаар зүйлийн 3 дахь

хэсэгт “Шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл өөрчилсөн тохиолдолд ял шийтгүүлсэн этгээдэд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг ял эдлэх хугацаанд оруулж тооцно” гэж тус тус заасан болно.

Иймд яллагдагчийн цагдан хорих хугацааг баривчилсан, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолох талаар нарийвчилсан зохицуулалтыг нэмж тусгалаа. Түүнчлэн шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд хамаарахгүй байх тухай тайлбарыг нэмлээ.

Ийнхүү яллагдагчийг цагдан хорих хугацааг тоолох хугацааг нарийвчлан тогтоож өгснөөр шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэх нь тодорхойгүй байсан асуудлыг нэг мөр шийдэх практик ач холбогдолтой юм.

#### **14.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийн “шүүхэд мэдүүлэх эрх”-ийг хангах шаардлагыг харгалзан прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг цахимаар оролцуулах тухай нэмэлтийг тусгалаа.

#### **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 14.5 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙД:**

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцсийн арга хэмжээ болгон хэрэглэхэд шууд нөлөөлөх нэг хүчин зүйл нь хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг нэмэгдүүлэх, уг арга хэмжээнд тавих техникийн хяналтыг сайжруулах явдал юм.

Иймд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэх талаарх холбогдох зохицуулалтыг тусгасан.

#### **15.8 дугаар зүйлийн 5.1 дэх заалт:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн шийдвэрийг прокурор, оролцогч эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг мөн зүйлийн 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл түүний эзгүйд томилогдсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ гэж заажээ.

Гэвч Ерөнхий шүүгч, эсхүл түүний эзгүйд томилогдсон шүүгч гомдлыг хянаад хүчингүй болгох эрх хэмжээг мөн зүйлийн 5 дахь хэсэгт хуульчлаагүй орхигдуулсан байх тул шүүхийн практикт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон төсөөтэй хэрэглэж байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад шүүх гомдлыг хянан шийдвэрлээд, хүчингүй болгох тухай зохицуулалтыг нэмж тусгалаа.

## **ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД:**

Гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн хүнд холбогдох хэргийг богино хугацаанд хянан хэлэлцэж шийдвэрлэх нь нэг талаас хэргийн оролцогчийн эрхийг хангах, хохирогч талын зөрчигдсэн эрхийг шуурхай сэргээн эдлүүлэх, нөгөө талаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болон цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой юм.

Шүүхийн нэгдсэн мэдээнээс үзэхэд анхан шатны шүүхүүд 2020-2022 онд 47440 хүнд холбогдох 39735 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэснээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт заасан тусгай журмын дагуу хялбаршуулсан журмаар 15347 хүнд (32.3 хувь) холбогдох 14016 хэргийг (35.3 хувь) хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс 49.6 хувь буюу 6949 хэргийг нийслэлд, 50.4 хувь буюу 7067 хэргийг орон нутагт тус тус хянан шийдвэрлэжээ.

### **17.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:**

Манай улсад сүүлийн 3 жилд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоог бусад улсын эрүүгийн хэргийн статистик үзүүлэлттэй харьцуулж үзэхэд харьцангуй доогуур байна. Үүнд нөлөөлж буй нэг хүчин зүйл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй” гэж заасантай холбоотой юм.

Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдэд оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг харгалзан (1 жил хүртэл, 1-5 жил, 2-8 жил, 5-12 жил хорих) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “найман жилээс дээш хугацаагаар” гэснийг “Арван хоёр жилээс дээш хугацаагаар” гэж өөрчлөхөөр тусгалаа.

### **17.2 дугаар зүйлд 5 дахь хэсэг нэмэх тухай:**

Шүүхийн практикаас үзэхэд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүн өмгөөлөгч авахаас татгалзаж, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “өөрийгөө өмгөөлөх” эрх, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно.” гэж заасныг тус тус баримтлан шүүх хуралдаанд өөрийгөө өмгөөлж оролцох хүсэлтийг бичгээр гаргах явдал түгээмэл байна.

Иймд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнөөс бусад үндэслэлээр оролцогч давж заалдах гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхийг мөн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт хязгаарласныг харгалзан Монгол Улсын



Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан иргэний “хууль зүйн туслалцаа авах” эрхийг баталгаатай хангах, Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” үүргийг хэрэгжүүлэх хүрээнд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзаж буй яллагдагчид үнэ төлбөргүй өмгөөлөгч томилж (томилогдсон өмгөөлөгч) оролцуулах зохицуулалтыг тусгалаа.

### **17.2 дугаар зүйлд 6, 7 дахь хэсэг нэмэх тухай:**

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт заасан тусгай журмаар явагдах тул энэхүү бүлэгт яллагдагч болон хохирогчийн эдлэх эрхийг тусгайлан хуульчлах зохицуулалтыг тусгалаа.

### **17.2 дугаар зүйлд 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг нэмэх тухай:**

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, эсхүл хэд хэдэн яллагдагч хамтран үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн бол тухайн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой эсэхийг нарийвчлан зохицуулаагүй.

Гадаадын улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судалж үзэхэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, эсхүл гэмт хэргийг хамтран үйлдсэн яллагдагч нар гэм буруугаа бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн бол тэдэнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байна. Тухайлбал, Украин улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 469 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэргийг хамтран үйлдсэн сэжигтэн, яллагдагч нарт холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нөхцлийг хуульчилсан байна.

Иймд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, эсхүл хэд хэдэн яллагдагч хамтран үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн бол тухайн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх боломжтой эсэх талаар хуульчлаагүй орхигдуулж, тодорхойгүй байдал үүсгэж байна. Иймд хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх зохицуулалтыг нэмж тусгалаа.

### **17.3 дугаар зүйлд 5, 6, 7, 8, 9 дэх хэсэг нэмэх тухай:**

Прокурор эрүүгийн хариуцлагын талаар яллагдагчтай тохиролцоо хийсэн баримтад тавигдах шаардлага, прокурорын яллах дүгнэлтийн хавсралтад тусгавал зохих мэдээллийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт хуульчилж, улсын хэмжээнд нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн прокурор яллагдагчийн гэм буруу, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар яллагдагчийн хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан саналыг яллах дүгнэлтийн хавсралтад тусгаж, хэргийг 7 хоногийн дотор шүүхэд шилжүүлэхээр тусгасан. Ингэснээр прокуророос шүүхэд хэргийг шилжүүлэх процессын хугацаа тодорхой болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал хангагдах юм.

Прокурор хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх саналтай хэргийг хэзээ, аль шүүхэд шилжүүлсэн, мөн прокуророос эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хэрхэх талаар зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.3 дугаар зүйлд нэмж тусгалаа.

#### **17.4 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Шүүгдэгч хүсэлтээсээ татгалзсан, эсхүл энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын аль нэг нь хангагдаагүй гэж үзэх үндэслэл байвал шүүх хэргийг прокурорт буцаах, эсхүл буцаахгүйгээр ердийн журмаар шийдвэрлэнэ.” гэж заасан бөгөөд дээрх үндэслэлээр гаргасан шүүгчийн захирамжийг оролцогчид эс зөвшөөрч гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхтэй эсэхийг хуульчлаагүйгээс шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүүтэй байдал үүсч байна.

Иймд хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх, эсхүл хэргийг прокурорт буцаах тухай шүүгчийн захирамжид шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх талаар хууль зүйн дүгнэлт хийгдэхгүй тул тус шийдвэрт прокурор, оролцогч гомдол, эсэргүүцэл гаргахгүй байх зохицуулалтыг нэмж тусгасан болно.

Ингэснээр тухайн завсрын шинж чанарыг агуулсан шүүхийн шийдвэрт оролцогч гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхийг хязгаарлаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал хангагдах юм.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт шүүхийн шийдвэрт талууд, оролцогч гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болох өөрчлөлтийг тусгасан болно.

#### **17.4 дүгээр зүйлд 10, 11 дэх хэсэг нэмэх тухай:**

Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар прокурорын гаргасан санал нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “... Тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх” шударга ёсны зарчмаас гадна “... Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх”-эд чиглэсэн Эрүүгийн хариуцлагын зорилгын наад захын шаардлагыг хангасан байх учиртай.

Ялын талаар тохиролцоо хийхэд хэргийн нөхцөл байдал, шүүгдэгчийн гэм буруугаа хэдийд хүлээсэн, мөрдөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзсан, ердийн журмаар шийдвэрлэсэн хэргээс ялгаатай ялын бодлогыг баримтлах шаардлагатай. Энэхүү ял шийтгэлийн бодлого нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн хэрэглээтэй шууд холбоотой бөгөөд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дэмжих үндсэн хөшүүрэг болно.

Иймд прокурор яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, яллагдагчийн хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар тохиролцоо хийхэд баримтлах нийтлэг аргачлал, журмыг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар хамтран баталж, хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн яллагдагчийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал төлөхөөс чөлөөлөх заалтыг нэмж тусгасан. Ингэснээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэгт яллагдагч хэдийд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход хэрхэн дэмжлэг үзүүлснээс хамаарч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхой хэмжээнд буурах тул хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүгдэгчийг зардал төлөхөөс бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх нь эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг дэмжих нэг хөшүүрэг болох юм.

### **АВЛИГЫН ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ АНХАН ШАТНЫ ЖУРМААР, ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАХ ТАЛААР:**

Авлигын гэмт хэрэг гэрчгүй, хохирогчгүй, оролцогч этгээдүүдэд бүгдэд нь давуу байдал бий болгож үйлдэгддэг нь илрүүлэхэд төвөгтэй болгож, ихэнх тохиолдолд нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хүрдэг, татагдан шалгагдах этгээд нь албаны нөлөөгөөр дамжуулан гэрчээр худал мэдүүлэг өгүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч этгээдэд нөлөөлөх, хэргийн баримт сэлтийг устгах, өөрөө саадгүй оргон зайлах зэргээр нотлох ажиллагаанд саад учруулах, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хил дамжуулан шилжүүлэх, нуух, угаах өндөр эрсдэлтэй байдаг. Улмаар шүүхэд нотлох ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн, эзлэхүүн ихтэй шинжээчийн дүгнэлт, нууц мөрдөн шалгах ажиллагааны арга, техникээр бий болгосон баримтуудыг ашиглан зарим гэмт хэргүүдийн хувьд тухайлбал, үндэслэлгүй хөрөнгөжих, мөнгө угаах зэрэгт эрүүгийн эрх зүйн уламжлалаас өөр зарчмуудад тулгуурлаж нотлох ажиллагаа явагддаг зэргээс авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд эхний ээлжинд цаг алдахгүй, шуурхай байдлыг хангах, хоёрдугаарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөх болон прокурорын байгууллага дагнасан байгааг харгалзан шүүхийн шатанд ч мэргэжил, туршлагын ахиу түвшний бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай нь авлигын ерөнхий нөхцөл байдал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэх үеэр тогтоогдсон.

Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх хараат бус, хариуцлагатай, мэдлэг, ур чадвар мэргэшсэн, иргэдийн итгэл хүлээсэн шүүгч, шүүхийн тогтолцоог бий болгож бэхжүүлэхэд дагнасан шүүх байгуулахаас илүүтэйгээр шүүхийн ердийн тогтолцоонд

тулгуурласан боловч шүүгчдийн корпусын хамгийн ур чадвар, туршлага бүхий хэсгээс шүүх бүрэлдэхүүнийг бүрдүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цөөн шат, дамжлагатай шийдвэрлэх замыг сонгох нь бусад хувилбартай харьцуулвал сөрөг үр дагавар багатайгаар зарим давуу талыг бий болгох боломжтой байна.

Монгол Улсын хувьд тодорхой төрлийн гэмт хэргийг үр дүнтэй, богино хугацаанд, шударга ёсыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэдэг тогтолцоог эрэлхийлж буйн хувьд өөрийн уламжлалт туршлагад тулгуурлаж, авлигын гэмт хэргийг бүх давж заалдах шатны шүүх, эсхүл хэргийн ачааллаас хамааран зөвхөн Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хэлэлцэж, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим давж заалдах журмаар хэлэлцдэг байхаар зохицуулах боломжтой юм.

Иймд анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй бүх шүүхийг анхан шатны шүүх, давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй бүх шүүхийг давж заалдах шатны шүүх гэж үзэх боломжгүй болох учир анхан, давж заалдах шатны шүүхийн тодорхойлолтод Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн талаарх өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлд тусгасан.

Авлигын хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн тогтолцоонд шуурхай байдлыг хангахын тулд хоёр шатлалтай болгож буй тул зохист буюу шударга процессын зарчмыг хангах хүрээнд шүүгдэгчийн процессын эрхийг баталгаажуулахын тулд авлигын гэмт хэргийг анхан шатны журмаар хэлэлцэхдээ бүх хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр хэлэлцэх нь зүйтэй байна. Энэ нь хуулиар тогтоосон давж заалдах шатны шүүхэд хэргийг хэлэлцэх бүрэлдэхүүнтэй шүүгчийн тооны хувьд тохирч байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор авлигын гэмт хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх зохицуулалтыг нэмж тусгалаа. Харин авлигын гэмт хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхдээ таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байхаар нэмж тусгасан болно.

Ингэснээр мэргэжлийн алдаа гаргах магадлалыг бууруулж, шүүгч бүрийн саналын нууцыг хадгалах боломж бүрдүүлэхээс гадна гаднын нөлөөлөлд автагдах эрсдэл нь нэг шүүгч хэрэг шийдвэрлэх тохиолдлоос мэдэгдэхүйц буурна.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн давж заалдах шатны шүүхийн ажиллагааг тусгасан Гучинесдүгээр бүлэгт давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг өргөтгөж давж заалдах шатны шүүх хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан 39.13 дугаар зүйлийг шинээр нэмлээ. Энэ зүйлд давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг шинээр тодорхойлж буйтай холбоотойгоор бусад онцлогуудыг тусгасан болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хяналтын шатны шүүхийн ажиллагааг тусгасан Дөчдүгээр бүлэгт хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг өргөтгөж хяналтын шатны шүүх хэрэг, маргааныг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан 40.13 дугаар зүйлийг шинээр нэмсэн. Энэ зүйлд хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг шинээр тодорхойлж буйтай холбоотойгоор бусад онцлогуудыг тусгалаа. Зохист буюу шударга процессын шаардлагыг хангах үүднээс давж заалдах журмаар хэрэг хэлэлцэж буй хяналтын шатны шүүхийн гомдол хянах хүрээ хязгаарт зөвхөн хяналтын журамд хамаардаг “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн

албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэх” үндэслэлийг нэмж тусгасан болно. Ингэснээр шүүхийн шатанд гаргасан гомдлоор хэргийг хянах үндсэн гурван шалгуурыг бүгдийг шалгах боломжтой болох юм.

### **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 34.16 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙД:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болон 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсон” бөгөөд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаах, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээгүй болсон.

Ийнхүү анхан болон давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүх хуралдаанаас эрүүгийн хэргийг прокурорт буцаах шүүхийн эрх хэмжээг хүчингүй болгохдоо давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээг хамтад нь хүчингүй болгосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зарим алдааг зөвтгөх хууль зүйн боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон.

Дээрх нөхцөл байдлууд нь шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хуулийг буруу хэрэглэсэн алдаа зөрчлийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар илрүүлсэн тохиолдолд тухайн хэргийг доод шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх замаар уг алдааг зөвтгүүлж, гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэлийг хүлээлгэх, хохирогчийн болон нийтийн эрх ашгийг нөхөн сэргээж шударга ёсыг тогтоох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй, цаашилбал гэм буруутай этгээд ял завших, улмаар шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах иргэний эрх ноцтой зөрчигдөх нөхцөл байдлыг бий болгосон.

Зөвхөн анхан шатны шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шаардлагатай болсон, эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд хуульд заасан журам зөрчигдсөн талаар талуудын гаргасан гомдлыг шийдвэрлэх шаардлагатай нөхцөлд шүүх хуралдааныг нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулж, шаардлагатай ажиллагаа явуулахыг прокурорт даалгах замаар мөрдөн байцаалтын шатанд гарсан хууль хэрэглээний алдааг зөвтгөх зохицуулалт үйлчилж байна.

Хэргийн бүрдэл хангагдаагүй буюу мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг дутуу шалгасан, хэрэгт цугларсан нотлох баримтууд нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг хөдөлбөргүй тогтооход хүрэлцэхүйц байх нотолгооны стандартыг хангаагүй, түүнчлэн мөрдөн байцаалтын шатанд оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан болон нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн алдааг шүүхийн шатанд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэгт заасан журмын дагуу 60 хоногт багтаан

нөхөн гүйцэтгэх боломжгүй, хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилж, эсхүл зарчмын өөр агуулгатай ял сонсгох шаардлагатай нөхцөлд хуулийн зорилт, нийтлэг зарчмуудад нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлага үүссэн байна.

Иймд шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг зөвхөн нэг удаа 60 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, шүүхээс даалгасан ажиллагааг прокурор шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлэх боломжгүй бол шүүх хуралдааныг 60 хүртэл хоногоор хойшлуулсаныг дахин нэг удаа 30 хүртэл хоногоор нэмж хойшлуулах зохицуулалтыг тусгалаа.

**УЛСЫН ИХ ХУРЛААС 2022 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР БАТАЛСАН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БУЙ АСУУДЛЫН ТУХАЙД:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3-т “энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах;” мөн хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.3-т “энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах;” гэснийг тус тус хүчингүй болгосон нь мөн хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянана.”, 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянана.”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүх хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхдээ анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг бүрэн хянаж үзнэ.” гэж заасантай зөрчилдсөн байна.

Ийнхүү давж заалдах шатны зарим шүүх анхан шатны шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцээгүй, Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн алдааг илрүүлсэн боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар давж заалдах шатны шүүх нь хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхгүй болсон гэж дүгнэн, анхан шатны шүүхийн хуульд нийцээгүй шийдвэрүүдийг хэвээр үлдээн шийдвэрлэж байна.

Тухайлбал, хууль бус бүрэлдэхүүнээр хэрэг шийдвэрлэсэн, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг үндэслэлгүйгээр прокурорт буцаасан, түүнчлэн хэргийн зүйлчлэлийг үндэслэлгүйгээр хөнгөрүүлсэн, эсхүл хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж ял завшуулсан зэрэг анхан шатны шүүхийн гаргасан хууль хэрэглээний ноцтой алдааг илрүүлж, энэ талаар оролцогчийн гаргасан давж заалдах гомдол, прокурорын бичсэн эсэргүүцэл хууль зүйн үндэслэлтэй талаар дүгнэлт хийсэн атлаа тухайн алдаа зөрчлийг зөвтгүүлэх зорилгоор давж заалдах шатны шүүх хэргийг анхан шатны шүүхэд буцааж, хэргийг дахин

хэлэлцүүлэх эрхгүй гэж дүгнэн холбогдох шийдвэрүүдийг хэвээр үлдээж буй нь Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт, нийтлэг зарчмууд болон уг хуулийн бусад хэм хэмжээтэй илтэд зөрчилдөж байгаа юм.

Анхан шатны шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, эсхүл шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн алдааг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас тогтоосон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасны дагуу тухайн шийдвэрийг хүчингүй болгохоор хуульчлан заасан бөгөөд шүүхэд үүрэг болгосон энэхүү хэм хэмжээ өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Гэтэл хууль тогтоогч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хүчингүй болгохдоо, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрхэн зөвтгөх, дутуу хийгдсэн мөрдөн шалгах ажиллагааг нөхөн гүйцэтгэх зохицуулалтыг хуульчлахгүй орхигдуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх (эсхүл цагаатгах) тогтоол, магадлалыг хүчингүй болгосон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ямар журмаар үргэлжлүүлэн явуулахыг хуульд заахгүй орхигдуулсан тул давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ийнхүү шийдвэрлэсэн хэргийг цаашид хэрхэх нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл хэргийг анхан, эсхүл давж заалдах шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах, эсхүл прокурорт буцааж нэмэлт ажиллагаа хийлгэх талаар тогтоолд заах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Өөрөөр хэлбэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд зааснаар давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээр хэлэлцээгүй, тогтоогоогүй нөхцөл байдал, шинжлэн судлаагүй нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгох буюу шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзвэл хэргийн үйл баримтыг шинээр өөрчлөн тогтоох, түүнд үндэслэн хэргийн зүйлчлэл болон ялыг хүндрүүлэн өөрчлөх эрх хэмжээ олгогдоогүй юм.

Хяналтын шатны шүүхийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлд зааснаар анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянах зэрэг үндэслэлээр эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх эрх хэмжээг хуульчлан тогтоосон боловч ийнхүү хэргийг хянахдаа анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдоогүй, эсхүл үгүйсгэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, түүнийг нотлогдсон гэж үзэх, ямар нэг нотлох баримтыг нөгөөгөөс нь ач холбогдолтойд тооцох, анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, ямар ял оногдуулах тухай асуудлыг урьдчилан шийдвэрлэх эрхгүйгээс гадна шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан, өөрөөр хэлбэл хэргийн зүйлчлэл болон ялын төрөл, хэмжээг хүндрүүлсэн байдлаар хэргийг эцэслэн шийдвэрлэх эрхгүй болно.

Дээрх нөхцөл байдлууд нь шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хуулийг буруу хэрэглэсэн алдаа зөрчлийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар илрүүлсэн тохиолдолд тухайн хэргийг доод шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх замаар уг алдааг зөвтгүүлж, гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэлийг хүлээлгэх, хохирогчийн болон нийтийн эрх ашгийг нөхөн сэргээж шударга ёсыг тогтоох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй, цаашилбал гэм буруутай этгээд ял завших, улмаар шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах иргэний эрх ноцтой зөрчигдөх нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг хоорондын зөрчил, хийдлийг хуулийн зорилт, нийтлэг зарчмуудад нийцүүлэн арилгах зайлшгүй шаардлагатай байх тул манай улсын хууль хэрэглээний уламжлал, Монгол Улсын олон улсын гэрээ, Үндсэн хуулийн үзэл санаа, эрх зүй өндөр хөгжсөн улс орнуудын сайн туршлагыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ хуулийг буруу хэрэглэсэн алдаа зөрчлийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар илрүүлсэн тохиолдолд тухайн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг доод шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх замаар уг алдааг зөвтгүүлэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

Түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийн зүйлчлэл, ялыг хөнгөрүүлж өөрчлөх, эсхүл прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлж өөрчлөх талаарх зохицуулалтыг нэмж тусгалаа.

Дээрх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 болон 40.5 дугаар зүйлд шүүх прокурорын яллах дүгнэлтэд заасан зүйлчлэлээс өөрөөр хүндрүүлж зүйлчлэхгүй байх талаар зохицуулалтыг тусгалаа.

## **ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХ АСУУДЛЫН ТАЛААР:**

### **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 5.2 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ӨМГӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙД:**

Шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан нөхцөлийн дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой болох нь шүүхийн практикт хийсэн судалгаагаар харагддаг.

Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцох нь яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар баталгаажуулсан суурь эрхийн нэг юм.

Гэтэл практикт эрүүгийн хэргийн зарим оролцогч өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэтрүүлэн эдэлж, өмгөөлөгчөөсөө татгалзах, шинээр өмгөөлөгч авах, нэмж өмгөөлөгч авах зэргээр шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашигт сөргөөр нөлөөлж, оролцогчдод чирэгдэл үүсгэх явдал гарсаар байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа



давтагдаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.” гэж заасан нь шүүх хуралдааныг хойшлогдох явдлыг багасгахад чиглэсэн хэм хэмжээ боловч өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй, шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзсан, шинээр өмгөөлөгч авах хүсэлт гаргасан тохиолдолд түүний өмгөөлүүлэх эрхийг хэрхэн хангах нь өнөөгийн шүүхийн практикт тулгамдсан асуудал хэвээр байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хангах нь хүн хилсээр ял шийтгэгдэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдах чухал баталгаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна.” гэж заасан нь мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан заавал өмгөөлөгчтэй явуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарч байх тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд өмгөөлөгч томилон оролцуулж, шүүх хуралдааныг тасралтгүй явуулах нөхцөлийг хангах шаардлагатай.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан иргэний “хууль зүйн туслалцаа авах” эрхийг баталгаатай хангах, Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах тухай зохицуулалтыг тусгалаа.

## **ШҮҮГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫН ТУХАЙД:**

Шүүхийн сахилгын хорооноос 2022-2023 онд нэр бүхий 28 шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийн үндэслэлийг судалж үзэхэд Шүүхийн сахилгын хороо нь өргөдөл, мэдээллийн дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчид сахилгын шийтгэх оногдуулах эсэх асуудлыг шийдвэрлэхдээ шүүгчийн хууль хэрэглэсэн мэргэжлийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх шаардлага үүсэж байгаа нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн бүрэн эрх, чиг үүрэгтэй давхцаж байгаагаас гадна шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүний дотор хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хууль тайлбарлаж гаргасан шийдвэрийн талаар Шүүхийн сахилгын хорооны хийсэн дүгнэлтийг тухайн зөрчилд холбогдсон шүүгч хүлээн зөвшөөрөхгүй, үндэслэлтэйгээр маргах явдал цөөнгүй гарсан байна.

Иймд Шүүхийн сахилгын хороо болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн чиг үүргийн давхардлыг арилгаж, шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийн илт тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, эсхүл удаа дараа зөрчсөн талаар дээд шатны шүүхээс хийсэн хууль зүйн дүгнэлт болон зөрчил гаргасан шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэн шалгуулах тухай дээд шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн Шүүхийн сахилгын хороо тухайн зөрчил гаргасан шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх,

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг шийдвэрлэдэг байх өөрчлөлтийг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, хэрэгжүүлэхэд нөлөөлөх сөрөг үр дагавар арилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшлэх болно.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх техник, тоног төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэхтэй холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг харгалзан боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/141 тоот тушаалаар байгуулагдсан Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлсэн болно.

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/25 дугаар зүйлийн 25.7.6 дахь заалт:**

“25.7.6.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор анхан шатны журмаар хэрэг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн тогтоолыг дараах тохиолдолд давж заалдах журмаар хянан шийдвэрлэх:

25.7.6.а.шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй;

25.7.6.б. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

25.7.7.в.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн;

25.7.8.г.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.

#### **2/39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг:**

“39.7.Энэ хуулийн 43.1-д заасан үндэслэл бий болсон бол Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн шүүгчийг өөр шүүхэд шилжүүлнэ.”

#### **3/55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг:**

“55.2.Энэ хуулийн 50.1.23, 50.1.27-д заасан зөрчлийн талаар дээд шатны шүүх дүгнэлт гаргаж, Сахилгын хороонд мэдээлэл хүргүүлсэн нь тухайн зөрчил гаргасан шүүгчид холбогдуулан сахилгын хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болно.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Анхан шатны шүүх” гэсний дараа “, анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй давж заалдах шатны шүүх” гэж,

29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “тухайн шүүхийн Зөвлөгөөний” гэсний дараа “, эсхүл Ерөнхий зөвлөлийн “ гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “томилж болно.” гэсний дараа “Шүүгч тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй нэг гэр бүл, төрөл садангийн холбоотой болохоо Ерөнхий зөвлөлд мэдэгдсэн, эсхүл тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах хүсэлтээ гаргаж болно.” гэж, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн “Энэ хуулийн” гэсний дараа “ 43.1,” гэж, мөн хэсгийн “шүүгчийг” гэсний дараа “шилжүүлэх,” гэж, 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт заасан “анхан” гэсний дараа “болон давж заалдах шатны шүүх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “бол тухайн өдрөөс” гэснийг “бөгөөд шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч байхгүй бол сул орон тоо гарсан өдрөөс” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “32.2-т” гэснийг “32.2.1, 32.2.2-т” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “орон тоог” гэснийг “орон тооны дээд хязгаарыг” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн доор дурдсан агуулгатай дараах зүйл, бүлэг нэмсүгэй:

**1/194<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“194<sup>1</sup> дүгээр зүйл. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээнээс зайлсхийж эрэн сурвалжлагдсан ялтан этгээдийг түр саатуулах**

194<sup>1.1</sup>. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан ялтан этгээдийг эрэн сурвалжлан, олж тогтоосон тохиолдолд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын тогтоолоор 72 цаг хүртэл хугацаанд саатуулна.

194<sup>1.2</sup>. Энэ зүйлийн 194<sup>1.1</sup>-т заасны дагуу саатуулагдсан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан ялтан, этгээдийн ялыг солих, албадлагын арга хэмжээг хүчингүй болгож ял оногдуулах саналыг прокурорт даруй хүргүүлж, шүүхээр шийдвэрлүүлнэ.”

**2/“ХОРИН НЭГДҮГЭЭР <sup>1</sup> БҮЛЭГ:**

**“ХОРИН НЭГДҮГЭЭР <sup>1</sup> БҮЛЭГ  
ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ  
АВАХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

**240<sup>1</sup> дүгээр зүйл. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих**

240<sup>1.1</sup>. Шийдвэр гүйцэтгэгч хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн хяналт тавина.

240<sup>1.2</sup>. Шийдвэр гүйцэтгэгч яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

240<sup>1</sup>.3.Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнд хяналтын тоног төхөөрөмж ашиглан хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**2 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3 дахь заалтын “цагдан хорих” гэсний дараа “, хязгаарлалт тогтоох” гэж, 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсгийн “хүлээж авна.” гэсний дараа “Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй.” гэж, 185 дугаар зүйлийн 185.1 дэх хэсгийн “хүлээн авна.” гэсний дараа “Холбогдох этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авахад саад болохгүй.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2 дугаар зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

### **ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмжтэй холбоотой хөрөнгө гаргах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

2. Энэ тогтоолыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **“7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ**

1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор тухайн хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн өөрт нь ногдох хууль ёсны хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хураана.

2. “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг орлогыг ойлгоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу албадан гаргуулж хураасан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна.

4. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа, эд зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч улсын төсөвт, эсхүл хууль ёсны өмчлөгчид шилжүүлэх, хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

5. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өмчлөгч эсэхээс үл хамааран энэ хуульд заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа, эд зүйлийг хураан авч улсын орлого болгоно.

6. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн, эсхүл бусдын тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг өмчлөгчид нь мэдэгдэхгүйгээр ашиглаж гэмт хэрэг үйлдсэн бол шүүх



тухайн эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн өөрт нь ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж, хураана. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, орон байраар хангаж дэмжлэг үзүүлсэн болох нь тогтоогдвол шүүх тухайн хөрөнгө, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, орон байрыг хураана.

7.Шүүх хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

